

**ТҮЛШ, ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН
САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалтын аргаар:

Захиалагч: Шарын гол сумын Эрүүл мэндийн төв

Гэрээний нэр: Түлш шатахуун нийлүүлэх

Тендерийн дугаар: ДААШГСЭМТ/202012002

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ШАРЫН ГОЛ СУМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
ОРШИЛ**

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 80'000'000 хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар шалгаруулахад мөрдөнө.

Үнийн санал авах жишиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн ажлыг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах ажил буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ налуу үсгээр хаалтанд бичсэн жишиээ, зааврын оронд тохирох уг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Web: WWW.TENDER.GOV.MN

Нэг: УРИЛГА

Тендер зарлах хугацаа: 2020 -04-10

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ТҮЛШ, ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг WWW.TENDER.GOV.MN сайт дээр тавьсан болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Үнийн саналыг 2020-04-10 -ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө WWW.TENDER.GOV.MN сайгад байршуулсан байна.

Тендерийн нээх хугацаа 2020-04-20 өдөр 15 цаг 00 минут

Тендерт оролцогчдод дотоодын давуу эрх тооцохгүй.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана. ААНБ-н улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, татварын тодорхойлолт
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн 5.1.** Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд саналын хүчинтэй байна.
хүчинтэй байх
хугацаа
- 6. Алдааг 6.1.** Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж залруулах дараах байдлаар залруулна:
 - (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2.** Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал 7.1.** Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн болгосон үнэ, зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. **түүнийг**
үнэлэх 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ 8.1.** Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан олгох тухай холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд мэдэгдэл гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ 2. Тендерт оролцогч компанийн нэр дээрх түлш, шатахуун худалдан борлуулах тусгай зөвшөөрөл
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Хайрхан багийн задгайд байрлах эрүүл мэндийн төв, Үнэлгээний хорооны дарга Ц.Баярмаа утас 99914914</p> <p>Огноо: 2020 оны 04 дугаар сарын 20 -ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум эрүүл мэндийн төвийн өөрийн байр</p> <p>Огноо: 2020 оны 04 дугаар сарын 20-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 00 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ:</p> <p>ТҮЛШ, ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ, ДААШГСЭМТ/202012002</p>

БАТЛАВ :Эрүүл мэндийн төвийн ерөнхий эмч

Х.Хишигсүрэн

.....оны.....сарын.....

ШАТАХУУНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020.04.10 Шарын гол

1. Барааны тодорхойлолт:

- Нийлүүлэх шатахуун нь Монгол улсын MNS 0216 : 2017, MNS 0217 : 2017 стандартын шаардлагыг хангасан байх
- Тендерийн шалгаруулалтанд оролцож байгаа байгууллагын шатахуун түгээх станц нь “Шатахуун түгээх станцын Техникийн шаардлага MNS 4628-2013 Монгол улсын стандартын шаардлага хангасан байх
- Нийлүүлэгч байгууллага нь шатах тослох материалын “Итгэмжлэгдсэн лабартори”-той байх ба бүтээгдэхүүнүүдэд нь зохих хугацаанд шинжилгээнд хамрагдаж баталгаажсан байх
- Шатахуун түгээгүүрийн газар нь 24 цагийн үйлчилгээтэй байх

2. Стандарт: Монгол улсын стандарт:

MNS 0216 : 2017 Дизелийн түлш. Техникийн шаардлага

MNS 0217 : 2017 Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин

3. Эрүүл мэндийн төвд нийлүүлэх түлш, шатахууны нийт үнийн дүн=14000.000 төгрөг (арван таван сая төгрөг)

№	Нэр	Төрөл	Хэмжих нэгж	Үнэ
1	Бензин	АИ-92	л	1770
		АИ-80	л	1840
2	Дизель түлш	Дз	л	2420

БОЛОВСРУУЛСАН: ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

Ц.БАЯРМАА

Тав. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>3. Бараа нийлүүлэх</p> <p>4. Маргааныг шийдвэрлэх</p> <p>5. Ажлын хөтөлбөр</p> <p>6. Зөрчил, гологдол илрүүлэх</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр өхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>3.1. Техникийн тодорхойлолт дээр нэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн стандарт, шаардлагад нийцээгүй тохиолдолд захиалагч шаардлага тавьж, авахаас татгалзах, шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнээр солулах эрхтэй</p> <p>4.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гарана.</p> <p>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</p> <p>5.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>5.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>6.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгالت, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> |
|---|--|

- | | |
|---|--|
| <p>7. Зөрчил, гологдол арилгах</p> | <p>7.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> |
| <p>8. Зөрчил, гологдол арилгахгүй байх</p> | <p>7.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> <p>8.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|---|
| <p>9. Үе шатны ажлын хуваарь</p> | <p>9.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны</p> |
|---|---|

1 Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- | | |
|--|---|
| <p>10. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</p> | <p>ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> |
| <p>11. Алданги</p> | <p>9.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> <p>10.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p> <p>11.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p> |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

12. Ажил дуусгах 12.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.

13. Гэрээг цуцлах 13.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

13.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

14. Гэрээг 14.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол **цуцалсан үед** төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын **хийх төлбөр** үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна.

2 Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

15. Гүйцэтгэлээс 15.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг **чөлөөлөх** гүйцэтгэх боломжгүй болсон бол.

Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 1.1	Тендерт оролцогч компаний нэр дээрх түлш, шатахуун худалдан борлуулах тусгай зөвшөөрөл
---------	--

ГЕН 2.1	Ажил эхлэх 2020 он Ажил дуусгахаар төлөвлөсөн 2020 он
ГЕН 3.1	Чанарын баталгаат хугацаа 2 жил байна.
ГЕН 4.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,2%] ⁴ байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна.

- 3 Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.
- 4 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны сарын -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: төгрөг; 20.... онд: төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: төгрөг; 20.... онд: төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: төгрөг; 20.... онд: төгрөг.

4. Гүйцэтгэгч нь байршилтай хүчин чадал бүхий ам.метр талбай / шоо метр эзлэхүүн/-тай, суурь, хана, хучилттай,

давхар барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, туслах барилга /бусад ажил/-ын хамт оны дугаар сарын -ны өдөр эхэлж, оны дугаар сарын -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;

5.6. Техникийн тодорхойлолт;

5.7. Зураг;

5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :**5.9.** Санхүүжилтийн хуваарь; **5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр][Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны

дугаар]